



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ



Хэрэгжүүлэгч :

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих (ICED) төсөл

Улирал тутмын мэдээллийн товхимол
№ 4/2024



ЭРХЭМ ХҮНДЭТ ТҮНШҮҮД БОЛОН ХАМТРАН АЖИЛЛАГСАД ТА БҮХЭНДЭЭ ШИНЭ ОНЫ МЭНД ХҮРГЭЭ!

GIZ-ийн "Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих" (ICED) болон DeveloPPP-ийн "Монголын ЖДҮ-д чиглэсэн ногоон, тогтвортой санхүүжилт" (SFME) төслүүдийн хамт олноос 2024 онд бидэнтэй бүтээлчээр хамтран ажилласан Та бүхэндээ чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. Бидний хамтын ажиллагаа ирж буй 2025 онд өргөжин хөгжинө гэдэгт итгэл дүүрэн байна.

Шинэ оны мэнд хүргэе! Ирж буй 2025 ондоо аз жаргал, эрүүл энх, амжилт бүтээлээр дүүрэн байх болтугай!



ЭЗХЯ МОНГОЛ УЛС, БНСУ ХООРОНДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ АХЛАВ

Монгол Улсын Засгийн газраас экспортоо төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний татварын болон гарал үүслийн таатай нөхцөл бүрдүүлэхэд онцгой анхаарч байна. Худалдааг иж бүрэн хөнгөвчлөх ажлын хүрээнд Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 4 дэх шатны хэлэлцээ 2024 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 1-ний өдрүүдэд Сөүл хотноо явагдав. Хэлэлцээр бүх талуудад өгөөжтэй болж өндөрлөв.



ЭЗХЯ хөрөнгө оруулалт, бараа үйлчилгээний худалдаа, дижитал худалдааны асуудлаарх ажлын хэсгийн бүлгүүдийг ахалсан нь худалдааны саад бэрхшээлийг бууруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, эдийн засгийн төрөлжилтийг бэхжүүлэх зорилтын хүрээнд чухал үүрэг гүйцэтгэв. Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалахын сацуу бараа хилээр нэвтрүүлэхтэй холбоотой ариун цэврийн шаардлага, хорио цээр, стандарт, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зэрэг бүх асуудлыг зохицуулан, илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх нь тус хэлэлцээрээс хүлээгдэж буй голлох үр дүн юм.

ЭЗХЯ-НЫ ТӨЛӨӨЛӨЛ АНУ-Д ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН МОНГОЛЫН ӨДРҮҮДЭД ОРОЛЦОВ

Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөхүүд Нью-Йорк хотод 10-р сарын 14-25 өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын өдрүүд-2024” худалдаа, хөрөнгө оруулалтын цуврал арга хэмжээнд Эдийн засаг, хөгжлийн яамыг төлөөлөн оролцов. Мөн Вашингтон хотод Байгаль орчны судалгааны хүрээлэн (ESRI) компанийн оффист хоёр талт уулзалт хийж тус компанийн GIS системийг Монгол улсад болон Эдийн засаг, хөгжлийн яаманд ашиглах талаар ярилцаж, системийн танилцуулга сургалтад суулаа.

БНСУ-ын Сөүл хотод олон улсын Дэлхийн Ногоон Сан-ийн албаны хүмүүстэй GSF-ээс Монгол улсад хэрэгжүүлж буй төслүүдийн талаар хоёр талт уулзалт зохион байгуулав



ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД

ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛЖ БАЙНА



2024 оны наймдугаар сараас хэрэгжиж эхэлсэн Жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийг чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан 3 удаагийн сургалт, зөвлөх үйлчилгээнд нийт 56 бизнес эрхлэгчид үүнээс 69 % эмэгтэйчүүд хамрагджээ.

Төслийн гэрээт зөвлөхүүдийн гүйцэтгэж буй онол, дадлага хосолсон эдгээр арга хэмжээнүүдээр ЖДҮ эрхлэгчдийг бизнесээ хөгжүүлэх, өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ зах зээлд нэвтрэх, улмаар экспортлогч аж ахуйн нэгж болоход дэмжлэг үзүүлж байна. Чадавхжуулах хөтөлбөр нь 2025 онд үргэлжлэх бөгөөд бараа бүтээгдэхүүний экспортын талаархи сэдвүүд нэмэгдэх юм. Түүнчлэн ICED төслийн түнш - Нийслэлийн Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв (ЖДҮҮДТ) нь чадавхжуулах хөтөлбөрт хамрагдсан бизнес эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжтой бөгөөд энэхүү зээлийг нь ХХБ (Худалдаа хөгжлийн банк) болон бусад хэдэн арилжааны банкаар дамжуулан олгохоор ажиллаж байна.



КЛАСТЕРААР ДАМЖУУЛАН ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛНЭ



Экспортын баримжаатай бүтээгдэхүүний хөгжил нь ЖДҮ үйлчилгээний салбарын тогтвортой үйлдвэрлэл, чанарын стандартыг дагаж мөрдөх зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Эдгээр хүчин зүйлсэд хамтын ажиллагааны хэлбэр мөн чухал байр суурь эзэлдэг бөгөөд кластерийн хамтын ажиллагаа нь бизнесийн хөгжлийн нэг боломж юм. Иймээс Нийслэлийн ЖДҮҮДТ-с тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх, хүнсний ногооны үйлдвэрлэлд инновац, шинэ технологийг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээг бий болгох, хөгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг санаачлан хэрэгжүүлж байгаагийн нэг нь “Улаанбаатар хотын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг кластерийн хамтын ажиллагаагаар нэмэгдүүлэх нь” төсөл юм.

Нийслэлийн ЖДҮҮДТ-ийн хүсэлтээр ICED төсөл нь кластер хөгжүүлэх энэхүү санаачилгыг дэмжиж, Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 21-р хороо Ар Гүнтэд 40 га талбайд хүнсний ногооны кластер байгуулах боломж, нөхцөлийн суурь судалгааг 2024 оны 4-р улиралд хийж гүйцэтгэлээ.

Суурь судалгаагаар Улаанбаатар хот орчмын хүнсний ногооны үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хөрсний шинж чанарыг судалж, хүнсний ногооны кластер байгуулах, хөгжүүлэх боломжуудыг тодорхойлов.



НИЙСЛЭЛИЙН ЖДҮҮДТ-Д ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨХ АЖИЛЛАНА

Нийслэлийн ЖДҮҮДТ нь ICED төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр олон улсын зөвлөлтэй хамтран ажиллахаар боллоо. Олон улсын зөвлөх нь тус төвд урт хугацаагаар ажиллаж, сургалт, зөвлөх үйлчилгээний чанарыг сайжруулах, гадаад зах зээлийн нарийвчилсан судалгаа хийх, олон улсын зах зээлд гарахаар төлөвлөж буй ЖДҮ эрхлэгчдэд экспортын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр зөвлөн туслах юм.

Олон улсын зөвлөхийг нээлттэй зарлаж, сонгон шулгаруулсан. Олон улсын зөвлөх нь Нийслэлийн ЖДҮҮДТ-ийн багийг бүх талаар дэмжин хамтран ажиллах бөгөөд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд гаргах, Улаанбаатар хотын бизнесийн орчинд шинэ боломжуудыг бий болгох, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжихэд тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

“МОНГОЛЫН ЖДҮ-ИЙН ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ” ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН DEVELOPPP ТӨСӨЛ

GIZ нь “Монголын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тогтвортой, ногоон санхүүжилт” төслийг ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтынажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-ны санхүүжилтээр Худалдаа, Хөгжлийн Банк (ХХБ)-тай хамтран 2024 оны 3-р сараас 2026 оны 5-р сарын хооронд хэрэгжүүлж байна. Тус төсөл нь банкны чадавхыг бэхжүүлэх болон банкны харилцагч жижиг дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах гэсэн хоёр үндсэн чиглэлтэй.

ЖДҮ-Д ЗОРИУЛСАН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨ

ХХБ-ны харилцагч ЖДҮ нарт зориулсан сургалт, зөвлөх үйлчилгээг 2024 оны 10-р сараас зохион байгуулж эхэлсэн. Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ (Мандал сум) аймгийн бизнес эрхлэгчид хамрагдаж буй эдгээр сургалтууд нь бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, бүтээгдэхүүний хөгжүүлэлт, маркетинг, борлуулалтын стратегийг оновчтой боловсруулах зэрэг олон сэдвүүдтэй. Сургалт, зөвлөх үйлчилгээний хөтөлбөр нь 2025 онд үргэлжлэн хэрэгжих ба бизнес эрхлэгчид энэ хөтөлбөрт оролцож, ХХБ-ны тодорхой шалгууруудын хангаснаар төслийн хүрээнд байгуулагдсан тусгай сангаас хөнгөлөлттэй зээл авах боломжтой болох юм.



ХХБ-НЫ АЖИЛТНУУДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ



ХХБ-ны ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа 2024 оны 10-р сараас эхлэв. Банкны удирдлагын чиглэлээр 30 орчим жил ажилласан туршлагатай Германы Шпаркассе Сангаас томилогдсон зөвлөх Майкл Мейнике, Вернер Э.Тум нар тус банкны ЖДҮ-ийн санхүүжилтийн үйл явцын урьдчилсан үнэлгээг (ex-ante шинжилгээ) хийхээр Монгол улсад ажиллалаа.

Урьдчилсан үнэлгээгээр зөвлөхүүд банкны үйл ажиллагаанд тохиолдож буй үр ашиг багатай, шаардлагагүй алхмуудыг тодорхойлох, хүчин төгөлдөр зээлийн журамд дүн шинжилгээ хийх, ажлын урсгал, явцыг сайжруулах, харилцагч ЖДҮ нарт үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг боловсронгуй болгох, ногоон санхүүжилтийн хөгжлийг дэмжих зэрэг олон сэдвүүдээр зөвлөмж өгөх юм.

Дээрх ажлыг гүйцэтгэх явцад зөвлөхүүд GIZ, Sparkassenstiftung, ХХБ-ны удирдлага, зээлийн мэргэжилтнүүд, холбогдох ажилтнуудтай удаа дараа уулзаж, санал солилцож, харилцан туршлагаасаа хуваалцсан юм.



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНД ОРОЛЦОВ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг соёрхон баталж, Засгийн газраас 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан. "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг олон нийтэд таниулах, уялдаа холбоог хангах, хэрэгжүүлэх үүднээс шинээр байгуулагдсан Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Бүсчилсэн хөгжлийн үндэсний чуулганыг зохион байгууллаа.

Тус чуулганд хувийн хэвшил, олон улсын байгууллага, орон нутгийн иргэд, иргэний нийгмийн төлөөллүүд оролцож, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, бүсүүдийн хөгжлийг хязгаарлаж буй орон зайн хүчин зүйлс, сорилтуудын шийдлийн талаар харилцан санал солилцов.

Тус арга хэмжээг зохион байгуулахад ICED болон SFME төслүүд нь Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнг дэмжин ажиллаж, ICED төслийн менежер хатагтай Нуржамал Бокоева Европ дах бүс нутгийн хөгжлийн туршлагыг танилцуулж, Монгол Улсын Бүс нутгийн хөгжлийн бодлогыг боловсруулахад Монгол дах GIZ-ийн оруулсан хувь нэмрийг онцлон тэмдэглэв. Тухайлбал, 2021-2023 онуудад хэрэгжиж байсан GIZ PROGRES төсөл Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах, холбогдох ажилтнуудыг чадавхжуулж байсан бол ICED төсөл нь "Орон нутгийн хөгжлийн индекс" (LDI платформ) онлайн платформыг шинэчилж байна. Энэхүү платформ нь Бүсчилсэн хөгжлийн бодлогыг сумын хэмжээнд тодорхойлох, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.



СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГААС СУДЛАВ



SFME төсөл, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн хамтран 2024 оны 12-р сарын 1-7-ны хооронд БНСУ-ын Инчеон хотод сургалт, мэдээллийн аялал зохион байгуулав.

Сургалт, мэдээллийн аяллын хүрээнд Солонгосын бүс нутгийн хөгжлийн санаачилга, стратегийн тэргүүлэх чиглэлийн бодлого боловсруулагчид болон бүс нутгийн хөгжлийн мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, Инчеон хотын бүс нутгийн хөгжил, ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг инновацийн төв, стартап төв, бизнес инкубатор зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав.

Мөн Инчеоны үндэсний их сургуульд ЖДҮ эрхлэгчдийг бүс нутгийн хөгжлийн бодлогод оролцуулах, нэгтгэх, кластерын хөгжил болон бүсийн нутгийн тэргүүлэх чиглэлд тохирсон ногоон, тогтвортой санхүүжилтийн хөшүүргийн талаар онолын болон практик мэдлэгийг суралцав. Сургалт мэдээллийн аяллаас авсан мэдлэг мэдээлэл нь Монгол Улсын бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх, тогтвортой өсөлт, инновацийг дэмжих тусгай шийдлүүдийг боловсруулахад хувь нэмрээ оруулна гэдэг итгэж байна.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн, ЖДҮ эрхлэгчид, ICED-ийн төлөөлөл оролцсон нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй аяллын таван оролцогчийн бүх зардлыг SFME төслөөс санхүүжүүлэв.

“БЛОКЧЕЙН ТЕХНОЛОГИОР МОНГОЛЫН ДААТГАЛЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ” (ISBC) ТӨСЛИЙН ОЛОЛТ АМЖИЛТУУД



ISBC төслийг ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-ны DeveloPPP төр-хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөр болон “Монре Даатгал” ХХК хамтран санхүүжүүлж, GIZ болон “Монре Даатгал” ХХК хамтран 2021-2024 онуудад амжилттай хэрэгжүүллээ.

“Амжилтын өдөр” нэртэй төслийн хаалтын арга хэмжээг 2024 оны 11-р сарын 29-ний өдөр зохион байгуулж даатгал, санхүүгийн салбарын төлөөлөгчид оролцов.

ISBC төслийн Монгол Улсын даатгалын салбарыг хөгжүүлэхэд тус нэмэр болсон дараах амжилтуудыг онцож байна:

- **Эрсдэлийн мэдээллийн сан:** Бүс нутгийн эрсдэлүүдийг тодорхойлж, шинжлэхэд зориулсан платформыг (<https://riskmapping.mn/>) бий болгосноор бизнес эрхлэгчид болон иргэдэд эрсдэлээс зайлсхийх, багасгах, удирдах боломжийг олгож байна.
- **Блокчейн технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн:** Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан гал, үерийн эрсдэлийг хамарсан, хэн бүрэн ашиглахад хялбар, хямд даатгал бөгөөд энэхүү бүтээгдэхүүнийг гар утасны аппликейшнээр дамжуулан авах боломжтой.
- **Санхүүгийн боловсрол олгох, олон нийтэд мэдээлэл түгээх үйл ажиллагаа:** Манай орны даатгалын салбар нь маш бага буюу дотоодын нийт бүтээгдэхүүний ердөө 0.5 хувьтай тэнцдэг. Олон нийтэд даатгал, эрсдэлийн менежментийн ойлголтыг түгээх, хямд, хүртээмжтэй бүтээгдэхүүн санал болгох нь даатгалын зах зээлийг тэлэх, салбарын цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой юм. Иймд тус төслөөс Chartered Insurance Institute-н сургалтын хөтөлбөрөөр 500 гаруй даатгалын салбарын мэргэжилтнүүдэд сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулсан. Эдгээр мэргэжилтэнүүд нь ЖДҮ эрхлэгчид болон олон нийтэд даатгалын ач холбогдлыг таниулах сургалт, зөвлөх үйлчилгээг хүргэсээр байна.

Төслийн оролцогч талууд, үр шим хүртэгчид “ISBC төслийг шинэлэг инновац, технологид тулгуурлан зорилтот бүлгийг эрсдлээ удирдах боломжийг бий болгох” зорилгодоо хүрсэн байна гэж дүгнэлээ.

ISBC төслийн хэрэгжилтийн хугацаанд хамтран ажилласан бүх байгууллагууд, зөвлөхүүддээ талархалаа илэрхийлье. Та бидний хамтдаа бий болгосон үр дүнгүүд нь Монголын даатгалын салбарт шинэ өөрчлөлт, хөгжлийн эхлэлийг тавьсан гэдэгт итгэлтэй байна.



ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ БАЙНА

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор тусгажээ. Иймд “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, Засгийн газарт танилцуулж, Улсын их хуралд өргөн барих ажлын хэсгийг ICED төслийн түнш Хөрөнгө оруулалт худалдааны газар (ХОХГ) ахлан ажиллаж байна.

GIZ-ийн ICED ба “Just transition-ийг хэрэгжүүлэхэд эрх зүйн зөвлөгөө өгөх ба шүүх эрх мэдлийн байгууллагуудын чадавхыг сайжруулах” төсөл нар хамтран хууль эрх зүйн салбарт мэргэшсэн, туршлагатай зөвлөхүүдийг ажиллуулж, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.


ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

ХОХГ-с “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгийг 2024 оны 12-р сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага болон бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцож, санал бодлоо солилцлоо.

Хуулийн шинэчлэл нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын орчинд ил тод байдал, тогтвортой байдлыг бий болгоход чиглэсэн бөгөөд энэ нь Монгол Улсад бизнесийн орчныг сайжруулахад томоохон алхам болох юм.



ЭДИЙН ЗАСГИЙН ОЛОН ТАЛТ ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ (ICED) ТӨСӨЛ



Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны
Нийгэмлэг (GIZ)

Огноо: 2024 оны 12-р сар

Дизайн/Зураг: GIZ ICED төсөл

Холбоо барих: Г. Бүдханд
“Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих”
төсөл
3-р давхар, 38-р байр, Нэгдсэн Үндэстний
гудамж, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 210646, Монгол улс

Утас: (+976) 77117704
И-мэйл: gurtsog.budkhand@giz.de
Веб: www.giz.de/mongolia